



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/173

Чингис хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн
байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 10 хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улаанбаатар хот, аймаг, сумдын хооронд хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, хүнс тээвэр/-аас бусад орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд зогсоож, доторх хөдөлгөөний ажиллах цагийн хуваариар зохицуулж холбогдох дүрэм, журмыг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Төрийн аудитын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газрын нийт ажилчдын 10 хүртэл хувийн бүрэлдэхүүнтэйгээр, Монгол банк, Шүүх, Прокурорын газар, өмгөөлөл, нотариат тусгай горимоор 09:00-12:00, 14:00-17:00 цаг хүртэл богиносгосон цагаар ажиллуулсугай.

3. Эрүүл мэндийн байгууллага, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Улаан загалмайн хороо, Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шуудан харилцаа холбоо, шатахуун түгээх станц, уул уурхай, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Онон балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Эрчим хүч, дулаан усан хангамж, ариутгалын аж ахуй нэгж байгууллагууд нийт бүрэлдэхүүнээр, цагийн хязгаарлалтгүйгээр ажиллуулсугай.

4. Хүнсний зах, хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэрлэл, эмийн сан, автомат тооцооны машин, хэвлэл мэдээллийн байгууллага, дугуй засвар, эрх бүхий харуул хамгаалалтын байгууллагууд 09:00-18:00 цаг хүртэл хуваариар ажиллуулсугай.

5. Дээр дурдсанаас бусад байгууллага аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хориглосугай.

6. Уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ирсэн ажилтнуудыг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажиллуулахыг тухайн аж ахуй нэгж байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

• 231011524

7. Аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл түр зогсоож энэ хугацаанд Ерөнхий боловсролын сургуулийн улирлын амралтын болон цахим сургалтын зохицуулалт хийж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

8. Эрүүл мэндийн салбар, хариу арга хэмжээний баг, стратегийн ач холбогдол бүхий салбарын ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/-т үүрэг болгосугай.

9. Халдварын голомт бүхий сумдад хавьтал тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, эрт илрүүлэх, зохион байгуулалтын бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Шуурхай штаб /хурандаа Ж.Эрдэнэбат/-т тус тус үүрэг болгосугай.

10. Аймгийн нутаг дэвсгэрт голомт бүхий объект, албан байгууллага, орон сууцны орц хонгил, цонх, хаалга, цахилгаан шат, нийтийн тээвэр, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн зам талбай зэрэг байршилд халдваргүйжүүлэлтийн ажлыг шат дараатай зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Зооноз өвчин судлалын төв /Ц.Гэрэлмаа/-д тус тус даалгасугай.

11. Хэнтий аймгийн хэмжээнд бүх төрлийн согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйлчилгээг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хориглосугай.

12. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ